



“Хүлэмжийн хий санхүүжүүлэх
Төслүүдийг хөгжүүлэх нь”
Сургалт Семинар



Монгол улсын Цэвэр Хөгжлийн Механизмын асуудлууд

**БОЯ-ны Тогтвортой хөгжил, стратеги төлөвлөлтийн
газрын дарга**

А.ЭНХБАТ



- **Монгол улс 1993 оны 9 дүгээр сарын 30-нд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенци (1994 он)-д нэгдэн оржээ.**
- **Монгол Улсын Засгийн газар Уур амьсгалын үндэсний хороог байгуулж, уур амьсгалын үндэсний илтгэлийг боловсруулж, хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах бодлого стратеги болон дасан зохицох бодлого, тэдгээрийг хэрэгжүүлэх арга механизм стратегийн үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийг 2000 оны 7 дугаар сарын 19-нд батлав.**


Конвенцийн зорилго

Агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламжийг уур амьсгалын тогтолцоонд хүний үйл ажиллагааны улмаас нөлөөлж болох эгзэгтэй түвшинд хүргэхгүйгээр тогтворжуулахад оршино. Энэ түвшинд эдийн засгийн цаашдын тогтвортой хөгжлийг хангах, хүнс тэжээлийн үйлдвэрлэлийг аюулд учруулахааргүй, уур амьсгалын өөрчлөлтөд экологийн тогтолцоо байгалийн аясаараа дасан зохицоход хангалттай тийм хугацаанд хүрэх ёстой.

“Уур амьсгалын өөрчлөлт” конвенцийг хэрэгжүүлэх хүрээнд хийгдсэн ажлууд:


1. ХАА-д нөлөөлөх байдлын үнэлгээг өөрчлөн хийж уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний хөтөлбөр боловсруулан 2000 оны 7-р сард ЗГ-аар батлуулсан.
2. Уур амьслалын өөрчлөлтийн Үндэсний хороог ЗГ-ын тогтоолоор 2000 онд байгуулав.
3. Даян дэлхийн байгаль орчны сангийн дэмжлэгээр “Уур амьсгалын үндэсний илтгэл”-ээ боловсруулан 2001 онд Конвенцийн нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлсэн.
4. Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаанд дэмжлэг үзүүлэх нь (GEF) Даян дэлхийн байгаль орчны сангийн дэмжлэгээр НҮБ-ын хүрээлэн буй орчны хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй “Уур амьсгалын өөрчлөлтөнд бэлчээр, мал аж ахуйн өртөх, дасан зохицохуйн судалгаа”-г 2002-2004 онд хэрэгжүүлэв.

CO2 хийн ялгаруулалт, Монгол Улс 2005



CH₄ хийн ялгаруулалт, Монгол Улс 2005

Mongolia's Estimated Anthropogenic Methane Emissions by Source, 2005



Марракешийн (Morocco) талуудын бага хурлаас 3 шинэ саг байгуулахаар шийдвэрлэсэн нь

1. Дасан зохицох үйл ажиллагааг дэмжин, технологи дамжуулах эдийн засгийн өргөтгөл хийхэд “ Уур амьсгалын өөрчлөлтийн тусгай сан”
2. Ядуу буурай орнуудад дасан зохицох үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх явдлыг дэмжих зорилготой нэн ядуу орнуудад дасан зохицох зорилготой “ Нэн буурай хөгжилтэй орнуудын сан”
3. Уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох арга хэмжээг санхүүжүүлэх зорилготой “Киотогийн протоколын дасан зохицохуйн сан зэрэг болно.

Киотогийн протокол



Одоогийн байдлаар уг Протоколыг нийт 139 орон болон бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага батламжилсан. Конвенцийн 1 дүгээр хавсралтанд орсон орнуудын хүлэмжийн хийн ялгаруулалтын хувь 61.6% байна.

Хүлэмжийн хийнүүд:

1. Нүүрсхүчлийн хий
2. Метан
3. Азотын исэл
4. Гидрофторт нүүрстөрөгчүүд
5. Перфторт нүүрстөрөгчүүд
6. Гексафторт хүхэр

Киотогийн протокол батлагдсны ач холбогдол

2000 оноос хойшхи хугацаанд агаар дах хүлэмжийн хийн хэмжээг бууруулах асуудлыг улс орнуудын хувьд хуульчилж өгсөн явдал юм.

- Уур амьсгалын цочмог өөрчлөлт нь дулаарлаас үүдэлтэйг эрдэмтэд тогтоогоод байна

- Дэлхийн дулаарлын гол буруутан нь өндөр хөгжсөн орнуудын үйлдвэрлэлээс ялгарч буй хүлэмжийн хийн бохирдуулагч бодисууд юм.

- Энэ протоколын дагуу хөгжсөн орнууд ХХ-ийн ялгаралтыг бууруулах үүрэг хүлээж байгаа бөгөөд 2008-2012 он гэхэд хийн ялгаралтыг 1990 оны түвшинд хүртэл бууруулах зорилго тавьж байна.

- Үүний тулд ХХ-ийг өөр хоорондоо зах зээлийн үнээр худалдах, ХХ-г бууруулах, хамтарсан төсөл хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт, технологийн шинэчлэлт оруулах, шилжүүлэх арга замаар шийдвэрлэнэ.

Киотогийн протоколыг хэрэгжүүлэх механизм

Киотогийн Протоколыг хэрэгжүүлэх механизм нь

- ХХ-ийн ялгаралтыг бууруулах
- “Шингээлтийг” нэмэгдүүлэх
- Бусад оронд илүү хямд төсөр аргаар хэрэгжүүлэх арга замыг тодорхойлж өгч байгаа юм.

1.Хамтран хэрэгжүүлэх

(Joint Implementation-JI)

2.Цэвэр хөгжлийн механизм

(Clean Development Mechanism-CDM)

3.Ялгаруулалтыг (Хүлэмжийн хийн) худалдаалах

(Emission Trading -ET)

Ялгаруулалтыг худалдаалах (Emission Trading-ET)

Конвенцийн 1 дүгээр хавсралтын орнууд ХХ-ийн ялгаралтыг арай хялбар байдлаар бий болгох боломжтой мөн хавсралтын бусад орнуудаас ХХ-ийн ялгаралтын тодорхой хувийг авах явдал юм.

Энэ хувийг *CDM*, *JI* механизм хэрэгжүүлснээр бий болгож байна.



Цэвэр хөгжлийн механизм (Clean Development Mechanism - CDM)

1. Хавсралт 1-д орсон Талууд ялгаралтын баталгаажсан бууралт (CERs)-ын үүргээ биелүүлэх зорилгоор хавсралт 1-д ороогүй хөгжиж байгаа орнуудын нутаг дэвсгэр дээр тогтвортой хөгжлийн үзэл санаанд нийцүүлэн “цэвэр хөгжлийн механизм”-ийн төсөл хэрэгжүүлэх

2. ЦХМ –ийг COP-7-аар (2001,Марракеш) эцэслэн зохион байгуулсан.

3. ЦХМ-ийг одоо 10 төлөөлөгчтэй олон улсын Гүйцэтгэх байгууллага зохицуулж байна.

Хамтран хэрэгжүүлэх
(Joint Implementation - JL)

Конвенцийн 1 дүгээр хавсралтын орнууд мөн хавсралтын бусад орнуудтай хамтран ХХ- ийн ялгаралтыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг хамтран явуулна. Шилжилтийн эдийн засагтай орнуудад хэрэгжүүлэхэд тохиромжтой.

Үндэсний товчооны үйл ажиллагаа

- Өнгөрсөн хугацаанд анхны үндэсний хурлыг зохион байгуулж, төсөл боловсруулж хэрэгжүүлэх боломжтой салбар байгууллагуудын төлөөлөгчдөд зориулж 2 удаа хурал, семинар хийсэн.
- Цэвэр хөгжлийн механизмийн төслүүдийн хүлээн авч санал өгөх ажлыг хийж байна.
- БОЯ-н дээр Дэлхийн банкнаас санхүүжиж буй Японы PHRD техникийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн төсөл нь Киотогийн протоколийн хэрэгжилтийн хүрээнд :
 - Монголын уг үйл ажиллагаанд ажиллах боловсон хүчний чадавхийг сайжруулах, ХХ-г бууруулах үйл ажиллагааг санхүүжүүлэх ажлыг хэрэгжүүлэх
 - 2012 оноос хойшхи олон улсын уур амьсгалын өөрчлөлтийн талаархи чиг хандлагыг тодорхойлох зорилготой юм.

Цэвэр хөгжлийн механизмийн Үндэсний товчооны танилцуулга

- Монгол Улс Киотогийн протоколыг 1999 оны 12 сарын 15нд баталсан.
- Монгол Улсын ЦХМ-ийн Үндэсний Товчоо нь БОЯ-ны харъяа бөгөөд 2004 оны 11 сарын 18-нд сайдын тушаалаар байгуулагдаж үйл ажиллагаагаа эхэлсэн. НҮБ-ийн Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцийн нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэж албан ёсоор бүртгүүлсэн.
- 2006 оноос БОЯ-ны Тогтвортой хөгжил стратеги, төлөвлөлтийн газар нь уг Үндэсний Товчооны үүргийг хүлээн аваад ажиллаж байгаа.
- Үүсгэн байгуулагдснаар ЦХМ-ийн төслүүдийг хүлээн авч судлан улмаар үнэлгээ өгөх, төслүүдийг дэмжих, батлах, буцаах, түүнтэй холбоотой зохих албан бичгийг олгох, холбогдох ажлын хэсэг хороог байгуулах, төсөлд үнэлгээ өгөх журам, шалгуурыг боловсруулах үйл ажиллагаа явуулдаг.

Цэвэр хөгжлийн механизмийг төслийг хэрэгжүүлэхэд тавигдах шаардлагууд

- Киотогийн протоколыг хүлээн зөвшөөрсөн зөвхөн нэг л оролцогч талтай хамтран ажиллах
- Талуудын эрх ашгийг бүрэн хамгаалсан, сайн дурын үндсэн дээр тулгуурласан байх
- Үндэсний товчоог байгуулсан байх
- Хамтын ажиллагаа урт удаан хугацааны болон амьдралд хэрэгжихээр байх, төсөл хэрэгжсэний дараа тодорхой хэмжээний хүлэмжийн хий буурсан байх
- Төслийн дараа ХХ-н бууралт үргэлжлэн явагдах



Цэвэр хөгжлийн механизмын төслийн чиглэлүүд Монгол оронд

- Уурын бага болон дунд оврын халаалтын зуухны шинэчлэл, үйлдвэрүүдийн мотор солих
- Түлшний төрлийг боловсронгуй болгох
- Хог хаягдлын боловсронгуй менежмент
- Биотүлш нэвтрүүлэх
- Салхи, ус, нарны энергийг ашиглах
- Цахилгаан станцын менежментийг сайжруулах
- ХАА-н гаралтай ХХ-г багасгах төслүүд



25 2 2005

Анхаарал тавьсанд баярлалаа

